



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/8/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.23 № 335
танай _____ ны № _____ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Э.ЭРДЭНЭ-БУЛГАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бүрэгхангай сумын Төсвийн төлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, гэдруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын Төсвийн төлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бүрэгхангай сумын Төсвийн төлөрүүлэн захирагч нь 2025 онд сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нийт 2,335.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,314.4 сая төгрөг буюу 99.1 хувиар орлогыг бүрдүүлж, сумын орон нутгийн төсвөөс 2,009.3, ОНХС-гаас 1,037.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 552.5, нэмэлт дансаар 324.7, Байгаль хамгаалах нөхөн сэргээх дансаар 186.7 сая төгрөг буюу нийт 6,425.1 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 4,691.9 сая төгрөгийн зарцуулж, 1,733.2 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Аудитын гол асуудал

Бүрэгхангай сумын ТТЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар өмнөх оноос авлагыг 26.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, өглөгийн үлдэгдлийг 56.0 сая төгрөгөөр бууруулж ажиллажээ.

Мөн үндсэн хөрөнгө 799.8 сая төгрөгөөр өсч, бараа материал 8.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Шилэн дансанд мэдээлэх 144 мэдээлэлийг бүрэн мэдээлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
Эргэлтийн хөрөнгийн дүн		1,517,504.54	2,032,676.03
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		5,807,342.95	6,607,145.48
Нийт хөрөнгийн дүн		7,324,847.50	8,644,328.95
Нийт өр төлбөрийн дүн		95,954.37	39,883.54
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		7,228,893.13	8,604,445.41
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн		7,324,847.50	8,644,328.95
Санхүү үр дүнгийн тайлан			
Үйл ажиллагааны орлогын дүн		6,835,787.93	7,344,911.55
Үйл ажиллагааны зардлын дүн		5,361,733.54	5,944,464.37
Үйл ажиллагааны үр дүн		1,474,054.40	1,400,447.18
Үйл ажиллагааны бус үр дүн		38,365.04	26,658.80
Үйл ажиллагааны нийт үр дүн		1,435,689.35	1,373,788.37
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		866,779.43	866,779.43
Тайлант оны үр дүн		1,435,689.35	1,373,788.37
Эцсийн үлдэгдэл		5,793,203.78	8,604,445.41
Мөнгөн гүйлгээний тайлан			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн		5,923,991.19	6,425,207.88
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		3,837,374.23	3,882,014.58
Үйл ажиллагааны ЦМГ		2,086,616.96	2,543,193.29
Хөрөнгө оруулалтын ЦМГ		(1,405,721.26)	(1,953,413.03)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		(101,678.41)	(94,078.13)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		579,217.28	495,702.13
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		658,325.24	1,237,542.52
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,237,542.52	1,733,244.65
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		4,556,067.30	5,540,204.63
Урсгал зардал		2,272,831.10	3,802,589.74
Хөрөнгийн зардал		2,185,497.60	1,643,536.75
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		2,700,009.20	2,497,153.27
Улсын төсвөөс санхүүжих		2,335,009.20	1,944,621.07
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		365,000.00	552,532.20

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус сумын ТТЗ нь 2025 онд Урд бүсийн эдийн засгийн тулгуур төв болох, Иргэдийн сэтгэл ханамжид нийцсэн, олон улсад өрсөлдөхүйц ажил үйлчилгээг үзүүлж ажиллахаар алсын хараа, зорилтыг дэвшүүлж ажиллажээ.

Мөн сумын төсөвт байгууллагуудын төсвийн орлого, зарлага, зарцуулалтын үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, бодит мэдээ мэдээллээр хангах зорилго тавин Нийгэм-Эдийн засгийн олон талт салбарыг хөгжүүлж, төсвөө бүрдүүлсэн, манлайлагч, улсын жишиг сум байна гэсэн зорилготой ажилласан байна.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бүрэгхангай сумын ТТЗ нь 2025 онд сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг нийт 2,335.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,314.4 сая төгрөг буюу 99.1 хувиар орлогыг бүрдүүлж, сумын орон нутгийн төсвөөс 2,009.3, ОНХС-гаас 1,037.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 552.5, нэмэлт дансаар 324.7, Байгаль хамгаалах нөхөх сэргээх данснаас 186.7 сая төгрөг буюу нийт 6,425.1 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 4,691.9 сая төгрөгийн зарцуулж, 1,733.2 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Тав. Аудитын гол асуудал

Бүрэгхангай сумын ТТЗ-ийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар өмнөх оноос авлагыг 26.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, өглөгийн үлдэгдлийг 56.0 сая төгрөгөөр бууруулж ажиллажээ.

Мөн үндсэн хөрөнгө 799.8 сая төгрөгөөр өсч, бараа материал 8.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансанд мэдээлэх 144 мэдээлэлийг бүрэн мэдээлжээ.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн тооцож, орлогыг бүрдүүлж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 15.5 сая төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс 1.9 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг залруулж, 3.0 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 10.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Үүнд: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т *“Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.”* гэж заасны дагуу аудитаар илэрсэн 1.9 сая төгрөгийн 2 алдааг залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Тус сум нь Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр “Цэвэр орчин-цэмцгэр Бүрэгхангай” төслийг хэрэгжүүлэхдээ хоолны зардалд 0.8, усны зардалд 0.1 буюу нийт 0.2 сая төгрөгийг батлагдаагүй зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д *“Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”*, 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”*, 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”*-ын 3 дугаар зүйлийн 3.5-д *“Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ”*, 3 дугаар зүйлийн 3.7-д *“Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д *“Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.”* гэж заасныг тус тус үндэслэн гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.1.2 Төлбөрийн акт

Тус сум нь Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр “Аялал жуулчлал эвент арга” хэмжээг зохион байгуулахдаа 1.0 сая төгрөгийг хоолны зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д *“Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”*, 18 дугаар зүйлийн 18.1-д

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5-д “Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ”, 3 дугаар зүйлийн 3.7-д “Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.1.3 Төлбөрийн акт

Тус сум нь Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр төлөвлөгдөөгүй “Ойн менежментийн төлөвлөгөө” гэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр “Мөнх ногоон жодоо” ХХК-тай 3.2 сая төгрөгөөр гэрээ байгуулан урьдчилгаа санхүүжилт болох 1.7 сая төгрөгийг шилжүүлсэн боловч тус гэрээний хэрэгжилт 2025 оны 04 сарын 20-ны өдөр дуусахаар байсан ч тухайн арга хэмжээний гүйцэтгэлийг тайлант онд дүгнэж хүлээж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5-д “Энэ журмын 3.4-т заасныг үндэслэн төлбөрийн орлогын хэсгээр тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ”, 3 дугаар зүйлийн 3.7-д “Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн.” гэж заасныг тус тус үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2.1 Албан шаардлага

Тус сумын ЖДҮДС-гийн зээлийн 10.0 сая төгрөгийн үлдэгдэл нь 2012 оны зээл гэх боловч, эзэн холбогдогч нь тодорхойгүй, одоог хүртэл төлөгдөөгүй, анхан шатны баримтгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “ батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг 12.1 сая төгрөгөөр орлого төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 3.5 сая төгрөг буюу 29 хувийн орлого оруулж 71 хувиар орлого тасарсан байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	2	2			2			

**8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ	2	1,972.9	2	1,972.5								
Сумын ЗДТГ	2	6,247.5	2	6,247.5								
Сумын ИТХ	1	6,596.0			1	6,596.0						
Дүн	5	14,816.4	4	8,220.0	1	6,596.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын ИТХ	2	1,199.0			1	800.0						
Сумын ЗДТГ	4	5,872.9	2	717.9			2	5,155.0				
Сумын ТТЗ	5	13,005.1	3	2,983.0	1	10,022.1	1	0				
Сумын ОНХС	5	11,000.0	2	2,021.0	1	8,979.0	2	0				
Дүн	16	31,077.0	8	7,987.9	3	19,801.1	5	5,155.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сумын ИТХ	1	0					1	0
Сумын ЗДТГ	1	0					1	0
Сумын ОНХС	1	0					1	0
Дүн	3	0					3	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын ЗДТГ	1	1,567.0	1	1,567.0				
Сумын ИТХ	1	399.0	1	399.0				
Дүн	2	1,966.0	2	1,966.0				
Нийт дүн	5	1,966.0	2	1,966.0			3	0